



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/381

Булган сум

Эзэмшил газрын зориулалт өөрчлөх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны IX/19 дүгээр тогтоолоор баталсан "Булган сумын шинэчилсэн ерөнхий төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн П.Ганзул (ГЗ80022101)-ын Булган сум 6 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 1 дүгээр гудамж 104а тоотод байршилтай 6308009333 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 858 м2 газрын зориулалтыг нийтийн орон сууцны зориулалттай болгон өөрчилсүгэй.

2.П.Ганзултай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтийн байдалд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/105 дугаар захирамжийн П.Ганзултай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ